



ҮАГ

Үндэсний аудитын газар

Яам, агентлагийн
автомашин, үүрэн
телефоны ашиглалт



Автомашин, үүрэн телефоны зардлын лимитийг хэтрүүлэх явдал хавтгайрчээ

2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

Агуулга

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2
	Бүлэг 1	
	Автомашин хэрэглэх эрх зүйн актыг шинэчлэх шаардлагатай байна	
<u>Тайланг бэлтгэсэн:</u>		
ҮАГ-ын Нэгдүгээр газар	Оршил	3
<i>Тэргүүлэх аудитор Д.Ганбилэг</i>	• Дуудлагын болон байгууллагын автомашин хэрэглэх эрх зүйн акт шаардлагатай байна	4
<i>Аудитын менежер Ж.Батсайхан</i>	• Автомашин хэрэглэх лимитэд тавих хяналт хангалтгүй байна	8
<i>Ахлах аудитор С.Сэрчхорол</i>	• Автомашины бүртгэл бүрэн хөтлөгдөхгүй байна	10
<i>Аудитор С.Андруш Х.Баярмаа</i>		
<i>Шинжээч Ц..Эрдэнэчулуун</i>		
2006 оны 12 дугаар сар	Бүлэг 2	
	Үүрэн телефон хэрэглэх лимитийг хянахгүй байна	12
<u>Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</u>	• Үүрэн телефон хэрэглүүлэх эрх зүйн актыг шинэчлэх шаардлагатай байна	
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	• Албан тушаалтнууд лимит хэтрүүлжээ	15
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	• Холбогдох байгууллагын санал	16
ХАЯГ:	Хавсралтууд	17
<i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>		

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд яам, агентлагийн автомашин, үүрэн телефоны зардалд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Яам, агентлагуудын автомашин, үүрэн телефоны зардал үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэхийг шалгаж, дүгнэлт хийн, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын горимоор нотлох зүйл цуглуулан, дүн шинжилгээ хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад 13 яам, Засгийн газрын 30 агентлаг, төвүүдийн 80 хувийг төлөөлөл болгож хамрууллаа.

Аудитыг 2005 оны санхүүгийн баримт материалд, автомашины бүртгэлийг 2006 оны хагас жилийн санхүүгийн тайланд тулгуурлан гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1

Автомашин хэрэглэх эрх зүйн актыг шинэчлэх шаардлагатай байна



Оршил

1.1. Албан тушаалын, албан ажлын, дуудлагын автомашин хэрэглэх эрх зүйн дараахь актууд мөрдөгдөж байна:

- МУ-ын ЗГ-ын 1996 оны “Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай” 266 дугаар тогтоол
- ЗГ-ын 266 дугаар тогтоолын хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай МУ-ын ЗГ-ын 1997 оны 148 дугаар тогтоол
- МУ-ын ЗГ-ын 2000 оны “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашины зардал хэмнэх тухай” 51 дүгээр тогтоол (захирамж)

- МУ-ын ЗГ-ын 2001 оны “Төр, засгийн үйлчилгээний авто баазын талаар авах зарим арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоол
- МУ-ын ЗГ-ын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоол

1.2. Яам, агентлагийн албан тушаал болон албан ажлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын хавсралтаар, тэдгээрийн харьяа байгууллагуудын албан ажлын хэрэгцээний дуудлагын автомашиныг тус тогтоолын 5-д заасны дагуу Засгийн газрын гишүүдийн баталсан журмаар зохицуулж байна.

Дуудлагын болон байгууллагын автомашин хэрэглэх эрх зүйн акт шаардлагатай байна

1.3. Албан тушаалын автомашиныг Засгийн газрын гишүүд, албан ажлын автомашиныг дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга нар эрхийн дагуу хэрэглэж байна.

Албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэгчийн судалгаа:

№	Албан тушаал			Төрийн нарийн бичгийн дарга
	Яам, агентлаг	Сайд	Дэд сайд	
1.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	1	2	
2.	Онцгой байдал эрхэлсэн сайд	1		
3.	Мэргэжлийн хяналт эрхэлсэн сайд	1		
4.	Сангийн яам	1	1	1
5.	Хууль зүй, дотоод хэргийн яам	1	1	1
6.	Гадаад хэргийн яам	1	1	1
7.	Байгаль орчны яам	1	1	1
8.	Барилга, хот байгуулалтын яам	1	1	1
9.	Батлан хамгаалах яам	1	1	1
10.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1	1	1
11.	Зам тээвэр, аялал жуулчлалын яам	1	1	1
12.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	1	1	1
13.	Түлш, эрчим хүчний яам	1	1	1
14.	Үйлдвэр, худалдааны яам	1	1	1
15.	Хүнс, хөдөө аж ахуйн яам	1	1	1
16.	Эрүүл мэндийн яам	1	1	1
	Дүн	16	15	13

1.4. Засгийн газрын 1996 оны 266, 2001 оны 81 дүгээр тогтоолуудтай харьцуулан үзэхэд албан ажлын автомашиныг хэрэглэх эрхгүй 16 албан тушаалтан (яамдын төрийн захиргаа удирдлагын газрын дарга, сайдын зөвлөх, газрын дарга) хэрэглэж байна. (Нэрсийг хавсаргав)

Албан ажлын автомашин унах эрхгүй албан тушаалтны судалгаа:

№	Албан тушаал		Төрийн захиргаа удирдлагын газрын дарга	Сайдын зөвлөх	Газрын дарга нар	Дуудлагын буюу ажиллагсад	Нийт
	Яам, агентлаг						
1.	ЗГХЭГ				3		3
2.	Сангийн яам		1			1	2
3.	Хууль зүй, дотоод хэргийн яам					1	1
4.	Гадаад хэргийн яам		1				1
5.	Байгаль орчны яам					1	1
6.	Батлан хамгаалах яам		1	1	2		4
7.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам					1	1
8.	Зам тээвэр, аялал жуулчлалын яам				3	1	4
9.	Түлш, эрчим хүчний яам				2		2
10.	Үйлдвэр, худалдааны яам		1	1			2
11.	Хүнс, хөдөө аж ахуйн яам					1	1
	Дүн		4	2	10	6	22

1.5. Түүнчлэн Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын 5 дахь заалт болон хавсралтыг үндэслэн Засгийн газрын гишүүд өөрийн харьяа байгууллагуудад тогтоосон журмын дагуу дараахь албан тушаалтнуудад байгууллагын автомашин хэрэглүүлж байна:

Өөрийн байгууллагаас автомашин хэрэглэж байгаа албан тушаалтны судалгаа

№	Албан тушаал		Дарга	Дэд дарга	Зөвлөх	Газар хэлтсийн дарга нар	Дуудлагын	Бусад	Нийт
	Агентлагийн нэр								
1.	Онцгой байдлын ерөнхий газар		1	2	1	3	2		9
2.	Улсын мэргэжлийн хяналтын газар		1	2	1	2	11		17
3.	Тагнуулын ерөнхий газар		1	1	1		13	2	18
4.	Төрийн өмчийн хороо		1	1		3			5
5.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар		1				1		2
6.	Стандартчилал, хэмжил зүйн төв		1	1					2
7.	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар		1	1					2
8.	Оюуны өмчийн газар						2		2
9.	Хүүхдийн төлөө үндэсний төв		1				2		3
10.	Удирдлагын академи		1	1			2		4
11.	Төр засгийн үйлчилгээ, аж ахуйн газар		1	2			1		4
12.	Үндэсний татварын ерөнхий газар		1	2			2		5
13.	Улсын гаалийн ерөнхий газар		1	2					3
14.	Цагдаагийн ерөнхий газар		1						
15.	Хил хамгаалах ерөнхий газар		1	1			8		10
16.	Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв		1				3		4
17.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар		1	2	1		8	1	13
18.	Үндэсний архивын газар		1				2		3

19.	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар	1				4		5
20.	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	1				1		2
21.	Усны хэрэг эрхлэх газар	1	1					2
22.	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	1	2					3
23.	Зэвсэгт хүчний жанжин штаб	1	2			10		13
24.	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	2		2	12	1	18
25.	Төмөр замын хэрэг эрхлэх газар	1	1					2
26.	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	1	2		1	1	1	6
27.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1				1		2
28.	Гадаадын хөрөнгө оруулалтын газар	1						1
29.	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	1	2	3	8	4		18
30.	Биеийн тамир спортын улсын хороо	1				1		2

1.6. Дээрх судалгаанаас үзэхэд Улсын мэргэжлийн хяналтын газар 11, Тагнуулын ерөнхий газар 13, Зэвсэгт хүчний жанжин штаб 10, Иргэний нисэхийн ерөнхий газар 12, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар 4 автомашин тус тус дуудлагаар хэрэглэж иржээ.

1.7. Агентлагууд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан журмын дагуу суудлын автомашин хэрэглэж байгаа боловч зардал хэмнэх чиглэлээр автомашины ашиглалтыг сайжруулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахгүй байна.

- Ерөнхийлөн захирагчийн баталсан журам төдийлөн тодорхой бус тухайлбал, Төрийн өмчийн хороо, Улсын Гаалийн ерөнхий газар, Үндэсний татварын ерөнхий газар, Төмөр замын хэрэг эрхлэх газар, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг газруудад суудлын автомашин хэрэглүүлэх талаар нарийвчлан баталсан журамгүй байна.
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын туслах аж ахуй, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Жаргалант” цогцолбор зэрэг үндсэн чиг үүрэгт хамааралгүй газруудад автомашин хэрэглэж байна.
- Яамдын газрын дарга нар, ажилтнуудад албан ажлын болон дуудлагын автомашин хэрэглэх эрх хязгаарлагдсан байхад агентлагуудын дэд дарга, газар, хэлтсийн дарга нар ерөнхийлөн захирагчаас олгосон эрхийн дагуу автомашин хэрэглэж байна.

1.8. Хэдийгээр Засгийн газраас хэд хэдэн тогтоол гаргаж, албан тушаал, албан ажлын болон дуудлагын автомашин хэрэглэх талаар зохицуулалт хийсэн боловч энэ нь дараахь шалтгааны улмаас хэрэгжихгүй байна.

- Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын хавсралтаар баталсан албан тушаалын, албан ажлын болон дуудлагын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт өнөөгийн засгийн газрын бүтэцтэй уялдахгүй байна. (Хавсралт 1-ийг үзнэ үү)
- Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар 100 км-т 12-13 литр шатахуун зарцуулах автомашин хэрэглэхээр заасан бөгөөд бусад албан тушаалтнуудын хувьд шинэчлэн тогтоосон эрх зүйн акт гараагүйгээс 1996 оны 266 дугаар тогтоолоор 100 км-т 10 литр шатахуун зарцуулдаг автомашин хэрэглэж байх заалт үйлчилж байна.

Бүлэг 1 Яам, агентлагийн автомашин, үүрэн телефоны ашиглалт

Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын 6-ын “б”-д

“... Албан тушаалын болон албан ажлын, дуудлагын автомашин хэрэглэгчдэд хотын дотор шатахуун бага /100 км-т 10 л-ээс ихгүй/ зарцуулдаг автомашинаар үйлчлэх зохион байгуулалтын арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлсүгэй

Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын хавсралтын 1.1 дүгээрт

Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга тэдгээртэй адилтгах албан тушаалтан албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны хувьд 100 км-т 12-13 литрээс илүүгүй шатахууны зарцуулалт бүхий 15 сая хүртэл төгрөгийн үнэтэй суудлын автомашин хэрэглэнэ”

- Албан тушаалын болон албан ажлын автомашиныг зарим албан тушаалтнууд өөрийн харьяа байгууллагаас хэрэглэж байна.

Тухайлбал:

Харьяа байгууллагаас албан ажилд ашиглаж байгаа машины судалгаа:

№	Албан тушаалтан	Ямар байгууллагаас	Машины марк
1.	Түлш эрчим хүчний сайд	Эрчим хүчний судалгааны төв	Лэндкрузер 105
2.	Түлш эрчим хүчний дэд сайд		Лэндкрузер 105
3.	Түлш эрчим хүчний газрын дарга		Соната 5
4.	Түлш эрчим хүчний газрын дарга		Террано
5.	Үйлдвэр худалдааны сайд		Лэндкрузер 105, Мерседес бенз
6.	Үйлдвэр худалдааны дэд сайд	Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газар	Лэндкрузер 105
7.	Үйлдвэр худалдааны яамны төрийн захиргаа удирдлагын газрын дарга		Дэвүү
8.	Үйлдвэр худалдааны сайдын зөвлөх		Дэвүү
9.	Барилга, хот байгуулалтын сайд		Лэндкрузер 100,
10.	Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга	Газрын харилцаа геодези зураг зүйн газар	Соната 5
11.	Барилга, хот байгуулалтын дэд сайд		Тоёота лексус
12.	Мэдээлэл харилцаа холбоо технологийн газар	Мэдээлэл харилцаа холбоо хөгжлийн төв	Хюндай, Рекстон, Лэндкрузер
13.	Зам, тээвэр аялал жуулчлалын сайд	Иргэний нисэхийн ерөнхий газар	Лэндкрузер 105
14.	Зам, тээвэр аялал жуулчлалын дэд сайд		Лэндкрузер 105
15.	Зам тээвэр аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга		Лэндкрузер 105
16.	Зам тээвэр аялал жуулчлалын яамны ЭЗХА-ны газрын дарга		Киа кредос
17.	Зам тээвэр аялал жуулчлалын яамны аялал жуулчлалын газрын дарга	Тээвэр үйлчилгээний төв	Сорэнтон
18.	Зам тээвэр аялал жуулчлалын яамны тээврийн газрын дарга	Тээвэр үйлчилгээний төв	Мистрал
19.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	Лэндкрузер 105
20.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд		Соната 5

- Албан тушаалтнууд өөрийн харьяа байгууллагаас автомашин хэрэглэж болох эсэх, хэрэв болвол түүнийг хэрхэн журамлах талаар ямар нэг зохицуулалтгүй явж иржээ.
- Засгийн газрын 1997 оны 148 дугаар тогтоолоор Төр засгийн үйлчилгээний автобаазын автомашин, техникийн ашиглалтыг сайжруулж, сул зогсолт, үр ашиггүй гүйлтийг багасгах зорилгоор автомашин түрээслүүлэх журам баталсан боловч төрийн байгууллагуудад ашиглаж байгаа автомашиныг түрээслүүлэх талаар ямар нэг зохицуулалт алга байна.

- Онцгой байдлын ерөнхий газар 2005 оны 3 дугаар сарын 24-нд “Намдэмүн” ХХК-аас хуучин Соната-2 маркийн автомашин 2, Акцент маркийн автомашин 4-ийг авч, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2005 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 87 дугаар тушаалаар 5 автомашиныг түрээсээр явуулахыг зөвшөөрч, 3 дугаар сарын 25-нд гэрээ байгуулан жолооч нартаа олгожээ. Гэрээ байгуулагчид тус газрын ажилчдад өдөрт 50 км явахаар тооцон шатахууны үнэ, сарын цалин болон бусад нэмэгдлийг хувийн хадгаламжийн дансанд сар бүр шилжүүлж иржээ.

Хувийн харилцах дансны дүн автомашин худалдан авсан мөнгөн дүнтэй тэнцэх үед тус байгууллагын кассад тушаажээ.

Онцгой байдлын ерөнхий газар автомашин түрээслүүлснээр ямар нэг хууль зөрчөөгүй, харин сэлбэг хэрэгслийн зардал гараагүй хөрөнгө хэмнэсэн гэж тайлбарлаж байна.

- Автомашин түрээслүүлэх явдал түгээмэл биш ч цаашид энэ асуудлыг зохицуулах шаардлагатай.

Зөвлөмж: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Батболдод

- Төрийн байгууллагуудад дуудлагын болон байгууллагын автомашин хэрэглүүлэх журмыг боловсруулж, мөрдүүлэх
- Агентлаг, төвүүдийн автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулах
- Яамдын газрын дарга болон агентлагуудын дэд дарга, газар хэлтсийн дарга нарын автомашин хэрэглэх эрхийг зохицуулах

Автомашин хэрэглэх лимитэд тавих хяналт хангалтгүй байна

1.9. Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын 2-т “ хотын дотор баримтлах автомашин хэрэглэх лимитийг заажээ:

Ангилал	Лимит	
	Хугацаагаар	Км-ээр
Албан тушаалын	Хуанлийн хоногт	70
Албан ажлын	Ажлын хоногт	50
Дуудлагын	Ажлын хоногт	80

1.10. 2005 оны байдлаар тогтоосон лимитийг 9 байгууллагын 43 албан тушаалтан 185851 км-ээр хэтрүүлж, 27833,5 литр шатахуун зарцуулж,

(27833.5*825) 22,9 сая төгрөгийн илүү зардал гаргажээ. Товчоолсон дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Лимит болон шатахуун зарцуулалтын талаарх судалгаа:

Байгууллагууд	2005 он					
	Тогтоосон лимит(км)	Явсан лимит(км)	Зөрүү	Шатахуун		
				Зарцуулах (л)	Гүйцэтгэл	Зөрүү
Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар	44880	47774	-2894	3231,3	3821.92	-590,6
Гадаад хэргийн сайдын харьяа байгууллагууд	95855	157770	-61915	12461.15	20510.1	-8048.95
Үйлдвэр худалдааны сайдын харьяа байгууллагууд	167360	224839	-57479	33820	44620	-10800
Батлан хамгаалахын сайдын харьяа байгууллагууд	116145	120419	-4274	9291.6	9633.52	-341.92
Стандартчилал хэмжил зүйн төв	26400	33014	-6614	4356	5258.17	-902.17
Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	10800	12931	-2131	864	1034.48	-170.48
Сангийн сайдын харьяа байгууллагууд	79800	92954	-13154	11886	14004.62	-2118.62
Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын харьяа байгууллагууд	39050	57960	-18910	5076,5	7534,8	-2458,3
Байгаль орчны сайдын харьяа байгууллагууд	51150	52860	-1710	6649.5	6871.8	-222.3
Нийт дүн	696790	882641	-185851	96131,55	123965.01	-27833,5
Төгрөгөөр илэрхийлсэн дүн					≈	22,4 сая төгрөг

(Дэлгэрэнгүй хүснэгтийг хавсралт 2-оос үзнэ үү)

1.11. Албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэгчид лимитийг хатуу мөрдөж, хэтрүүлсэн шатахууны үнийг улирал тутам төлүүлж байх талаархи Засгийн газрын 1996 оны 266 дугаар тогтоолын заалт бүрэн мөрдөгдөхгүй байгаагаас лимит хэтрүүлэн зарцуулах явдал хавтгайрах хандлагатай байна.


1.12. Зарим байгууллагууд, тухайлбал Хүнс, хөдөө аж ахуйн яам, Ус цаг уур орчны шинжилгээний газар лимитийн хэтрэлт, хэмнэлтийг тооцдоггүй байна.

1.13. Зам тээвэр, аялал жуулчлалын сайд, дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, эдийн засаг хамтын ажиллагааны газрын дарга нар Иргэний нисэхийн ерөнхий газрын автобаазаас автомашин хэрэглэж, шатахууны төлбөрийг 2005 онд 6,3 сая төгрөгөөр, 2006 оны эхний хагас жилийн байдлаар 9,1 сая төгрөгөөр тус тус дутуу шилжүүлжээ. Түүнчлэн тус яамны хоёр газрын дарга Д.Наранпүрэв, Т.Батжаргал нар Тээвэр үйлчилгээний төвийн данстай автомашиныг хэрэглэж, тус төвөөс 2005 онд 2,8 сая төгрөгийн, 2006 оны эхний хагас жилийн байдлаар 1,6 сая төгрөгийн шатахууны зардлыг төлүүлжээ.

Зөвлөмж: Сангийн сайд С.Баяртсайханд:

- Албан тушаалын болон албан ажлын, дуудлагын автомашины лимитэд тавих хяналтыг сайжруулж, 2005 онд лимитээс хэтрүүлсэн зардлыг холбогдох албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэх

1.14. Аудитад хамрагдсан нийт яам, агентлагууд, Төр засгийн үйлчилгээний автобаазын санхүүгийн тайланд бүртгэлтэй 644 суудлын автомашины шатахууны зарцуулалтад судалгаа хийж үзэхэд 43 хувь буюу 280 нь 100 км-т 7-13 литр шатахуун зарцуулдаг байна.



1.15. Дэд сайд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар хот дотор 15,0 сая төгрөгөөс хэтрэхгүй үнэтэй автомашин хэрэглэх заалт тэр бүр хэрэгжихгүй байна. Аудитын явцад санхүүгийн тайланд автомашин орлогод авсан үнийн судалгаа хийсэн бөгөөд шалгуураас давсан үнэ бүхий автомашиныг хүснэгтээр үзүүлбэл:

Албан тушаал	Суудлын автомашины марк	Үнэ (төгрөгөөр)
Хууль зүй дотоод хэргийн дэд сайд	Бенз 230Ц	19.0 сая
Үйлдвэр худалдааны дэд сайд	Лэндкрузер 105	45.0 сая
АМГТХЭГ-ын дарга	Лэндкрузер 105	45.0 сая
ҮТЕГ-ын дарга	Соната 3	21.1 сая
Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга	Соната 5	19.0 сая
Удирдлагын академийн захирал	Рексон	21.4 сая
Сангийн дэд сайд	Ниссан патрол	58.2 сая
Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга	Лэндкрузер	51.6 сая
Онцгой байдлын ерөнхий газрын дарга	Лэндкрузер 105	57.5 сая
Төрийн өмчийн хорооны дарга	Соната 6	22.3 сая
Төмөр замын хэрэг эрхлэх газар	Лэндкрузер	51.9 сая
Стандарчилал хэмжил зүйн төвийн дарга	Лэндкрузер	17.5 сая
Түлш эрчим хүчний дэд сайд	Лэндкрузер 105	52.4 сая
Зам тээвэр, аялал жуулчлалын дэд сайд	Лэндкрузер 105	60.4 сая
Зам тээвэр, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга	Лэндкрузер 105	80.9 сая
Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга	Лэндкрузер 105	56.9 сая
Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга	Лэндкрузер 105	45.0 сая
Эрүүл мэндийн дэд сайд	Лэндкрузер	33.8 сая
Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга	Лэндкрузер	37.7 сая

Автомашинны бүртгэл бүрэн хөтлөгдөхгүй байна

1.16. Аудитын явцад Замын цагдаагийн газраас яам, агентлагт бүртгэлтэй байгаа автомашины судалгааг авч үзэхэд автомашины шилжилт хөдөлгөөний

бүртгэлийг хуулийн дагуу хийдэггүй байна. Жишээлбэл: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар Дулааны 4 дүгээр цахилгаан станц ХК-иас 2005 онд Ниссан патрол машин балансаас балансад шилжүүлэн авсан боловч өнөөг хүртэл ЗЦГ-т шилжүүлэг хийгээгүй, УМХГ 4 автомашин актлуулсан ч бүртгэлээс хасуулаагүй, УНДЕГ-ын нэрээр бүртгүүлсэн 3 автомашиныг хэн хаана хэрэглэж байгаа нь тодорхойгүй байна.

1.17. Хүнс, хөдөө аж ахуйн яам автомашины хувийн хэрэг хөтөлдөггүй нь автомашины сэлбэг хэрэгсэл, шатахууны зарцуулалтад тавих хяналт алдагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

1.18. НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газраас “21 дүгээр зуун тогтвортой хөгжил” төсөл хэрэгжиж дууссантай холбогдуулан 37.7 мянган ам.долларын хөрөнгийг Үйлдвэр худалдааны яаманд шилжүүлж, хүлээлгэн өгчээ. Үйлдвэр худалдааны яамны төрийн нарийн бичгийн дарга тушаал гаргаж хөрөнгийг балансад тусгахыг даалгасан боловч 13300 ам.долларын үнэ бүхий 1996 оны Соната 2 автомашиныг өнөө хүртэл бүртгээгүй байна. Одоо уг машиныг тус яамны ТЗУГ-ын орлогч дарга О.Эрдэнэ-очир хувьдаа ашиглаж байгаа ба шилжиж ирснээс хойш техникийн улсын үзлэгт оруулалгүй хөдөлгөөнд оролцож байна.



1.19. Автомашин худалдан авах хэрэгцээ шаардлагыг тооцдоггүйгээс ашиглалтын зардал ихтэй автомашин өндөр үнээр худалдан авч байна. Газрын тосны хэрэг эрхлэх газар (хуучин нэрээр) 2004 оны 10 дугаар сард 90.0 сая төгрөгөөр Хаммер Н2 автомашиныг ажлын хэрэгцээтэй гэж худалдан авчээ. Гэтэл ОБЕГ-ын удирдлага Төрийн өмчийн хороонд хөдөө туулах чадвар сайтай автомашин хэрэгцээтэй гэсэн хүсэлт гарган 2005 оны 2 дугаар сард балансаас балансад шилжүүлэн авчээ. Мөн удалгүй Онцгой байдлын сайд Батлан хамгаалахын сайдын хамтын ажиллагааны протоколыг үндэслэн 2006 оны 8 дугаар сарын 30-нд Батлан хамгаалах яаманд шилжүүлжээ.



1.20. Анхны худалдан авалтаас хойш хоёр жилийн хугацаанд гурван байгууллага дамжсан байгаа нь хэрэгцээгээ тодорхойлж чадахгүй, үрэлгэн байдалтай өндөр үнээр үр ашиггүй худалдан авалт хийсэн байна

БҮЛЭГ 2

Яам, агентлагийн автомашин, үүрэн телефоны зардлын үр ашигтай байдал

Үүрэн телефон хэрэглэх лимитийг хянахгүй байна



Оршил

2.1 Үүрэн телефон хэрэглэх талаархи дараахь эрх зүйн актууд мөрдөгдөж байна:

- МУ-ын ЗГ-ын 1999 оны “Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай” 84 дүгээр тогтоол
- ЗГ-ын 1999 оны 84 дүгээр тогтоолын хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай МУ-ын ЗГ-ын 2000 оны 144 дүгээр тогтоол
- МУ-ын ЗГ-ын 2004 оны “Төрийн холбооны ашиглалтыг сайжруулж, төсөвт зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай” 10 дугаар
- Тогтоол

Үүрэн телефон хэрэглүүлэх эрх зүйн актыг шинэчлэх шаардлагатай байна

2.2 Яамдад дараахь албан тушаалтнууд үүрэн телефон хэрэглэж байна:

Яамдад үүрэн телефон хэрэглэж байгаа ажилтнуудын судалгаа:

№	Албан тушаал Яам, агентлаг	Сайд	Дэд сайд	Төрийн нарийн бичгийн дарга	Төрийн захиргаа удирдлагын газрын дарга	Газрын дарга нар	Нийт
1.	Сангийн яам	1	1	1			3
2.	Хууль зүй, дотоод хэргийн яам	1	1	1			3
3.	Гадаад хэргийн яам	1	1	1			3
4.	Байгаль орчны яам	1	1	1			3
5.	Барилга, хот байгуулалтын яам	1	1	1	1		4
6.	Батлан хамгаалах яам	1	1	1	1	1	5
7.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1	1	1			3
8.	Зам тээвэр, аялал жуулчлалын яам	1	1	1			3
9.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	1	1	1			3
10.	Түлш, эрчим хүчний яам	1	1	1		1	4
11.	Үйлдвэр, худалдааны яам	1	1				2
12.	Хүнс, хөдөө аж ахуйн яам	1	1	1		2	5
13.	Эрүүл мэндийн яам	1	1	1			3
	Дүн	13	13	12	2	4	44

2.3 Засгийн газрын 1999 оны 84 дүгээр тогтоолтой харьцуулан үзэхэд үүрэн телефон хэрэглэх эрхгүй яамдын төрийн захиргаа удирдлагын газрын дарга, газрын дарга 6 албан тушаалтан үүрэн телефон хэрэглэж байна.

2.4 Түүнчлэн агентлаг, төвүүдэд дараахь албан тушаалтнууд үүрэн телефон хэрэглэж байна:

Агентлаг, төвүүдэд үүрэн телефон хэрэглэж байгаа ажилтнуудын судалгаа:

№	Албан тушаал Агентлагийн нэр	Сайд	Дарга	Дэд дарга	Зөвлөх	Газар хэлтсийн дарга нар	Бусад	Нийт
1.	Онцгой байдлын ерөнхий газар	1	1	2	1	14	2	21
2.	Улсын мэргэжлийн хяналтын газар	1	1					2
3.	Тагнуулын ерөнхий газар		1	2		1		4
4.	Төрийн өмчийн хороо		1			6		7
5.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	-	-	-				-
6.	Стандартчилал, хэмжил зүйн төв		1					1
7.	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар		1	2				3
8.	Оюуны өмчийн газар		1			1		2
9.	Хүүхдийн төлөө үндэсний төв		1					1
10.	Удирдлагын академи		1	1				2
11.	Төр засгийн үйлчилгээ, аж ахуйн газар		1	2				3

**Бүлэг 1 Яам, агентлагийн автомашин, үүрэн телефоны зардлын
вр ашигтай байдал**

12.	Үндэсний татварын ерөнхий газар	1					1	
13.	Улсын гаалийн ерөнхий газар	1	1				2	
14.	Цагдаагийн ерөнхий газар	1	1				2	
15.	Хил хамгаалах ерөнхий газар	1	1				2	
16.	Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв	1	1				2	
17.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	1	1	1			3	
18.	Үндэсний архивын газар	1					1	
19.	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар	1					1	
20.	Ус, цаг уур орчны шинжилгээний газар	1					1	
21.	Усны хэрэг эрхлэх газар	1	1				2	
22.	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	1	2				3	
23.	Зэвсэгт хүчний жанжин штаб	1	2		7		10	
24.	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	1		52		54	
25.	Төмөр замын хэрэг эрхлэх газар	1					1	
26.	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	1	2				3	
27.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1					1	
28.	Гадаадын хөрөнгө оруулалтын газар	1					1	
29.	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	1	2		11		14	
30.	Биеийн тамир спортын улсын хороо	1					1	
31.	Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв	1	2		2		5	
32.	Барилга, хот байгуулалтын үндэсний төв	1	2				3	
33.	Усны хэмнэлтийн төв	1	1				2	
34.	Тээвэр үйлчилгээний төв	1	2				3	
	Дүн	2	33	31	2	94	2	164

2.5 Засгийн газрын 1999 оны 84 дүгээр тогтоолтой харьцуулан үзэхэд үүрэн телефон хэрэглэх эрхгүй агентлагийн дэд дарга, зөвлөх, газар хэлтсийн дарга, төвийн дарга зэрэг 98 хүн үүрэн телефон хэрэглэж, 2005 он, 2006 оны эхний хагас жилийн байдлаар 45,1 сая төгрөгийн үргүй зардал гаргажээ. Тухайлбал: ШШГЕГазрын газар, хэлтсийн дарга нар 3-4 утас ашиглаж байна.

2.6 Дээр дурдсан 98 албан хаагчийн үүрэн телефон хэрэглэх эрхийг яам, агентлагийн эрх бүхий албан тушаалтан олгосон боловч Засгийн газрын 1999 оны 84 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

2.7 Түүнчлэн ЗГ-ын 1999 оны 84 дүгээр тогтоолын үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг баталсан хавсралтын зарим албан тушаалын нэр одоогийн засгийн газрын бүтэцтэй тохирохгүй байна. (Хавсралт 3-ыг үзнэ үү.)

2.8 Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг 5 байгууллага ИРИДИУМ буюу сансарын холбоог ажил үүргийн шаардлагатай гэсэн үндэслэлээр ашиглаж эхэлжээ.

2.9 2005 онд Хил хамгаалах ерөнхий газар 1,5 сая, ЗХЖШ 2005 онд 5,2 сая төгрөгийг төсвөөс, Зам тээвэр аялал жуулчлалын яам 2,2 сая төгрөгийг харьяа байгууллагаас сансрын холбооны зардалд төлжээ. Одоогоор сансрын холбоо ашиглах эрх зүйн акт байхгүй байна.

Зөвлөмж: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Батболдод

- Үүрэн телефон, (шаардлагатай гэж үзвэл) сансрын холбоо хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх

Албан тушаалтнууд лимит хэтрүүлжээ

2.10 Засгийн газрын 2001 оны 58 дугаар тогтоолоор дараахь лимитийг тогтоожээ:

Албан тушаал	Ярианы эрх	1 сарын лимит
Засгийн газрын гишүүд	Улс хоорондын ярианы эрхтэйгээр	150'000 төгрөг
Тогтоолд заасан бусад албан тушаалтан	Улс хоорондын ярианы эрхгүйгээр	65'000 төгрөг

2.11 Дээрх тушаалын заалттай харьцуулж үзэхэд 2005 оны жилийн эцсийн байдлаар 16.0 сая төгрөгөөр лимит хэтрүүлжээ.

Үүрэн телефоны лимит хэтрүүлсэн яам, агентлагийн судалгаа:

	Байгууллага	Хэтрэлт
1	Сангийн яам түүний харьяа байгууллагууд	-180000
2	Хууль зүй, дотоод хэргийн яам түүний харьяа байгууллагууд	-922849
3	Гадаад хэргийн яам түүний харьяа байгууллагууд	-5779249
4	Байгаль орчны яам түүний харьяа байгууллагууд	-493488
5	Барилга, хот байгуулалтын яам түүний харьяа байгууллагууд	-309600
6	Батлан хамгаалах яам түүний харьяа байгууллагууд	-740495
7	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам түүний харьяа байгууллагууд	-1121700
8	Зам тээвэр, аялал жуулчлалын яам түүний харьяа байгууллагууд	-840000
9	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам түүний харьяа байгууллагууд	-420000
10	Үйлдвэр худалдааны яам түүний харьяа байгууллагууд	-69000
11	Улсын мэргэжлийн хяналтын газар түүний харьяа байгууллагууд	-1211600
12	Онцгой байдлын ерөнхий газар түүний харьяа байгууллагууд	-1700100
13	Ерөнхий сайд болон Шадар сайдын харьяа байгууллагууд	-2260755
	Нийт	(16048836)

(Дэлгэрэнгүй тооцоог 4 дүгээр хавсралтаас үзнэ үү)

2.12 Засгийн газрын тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавихыг Сангийн сайдад үүрэг болгосон боловч хяналт хангалтгүй байна.

Сангийн сайд С.Баяртсайханд:

- Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны лимитэд тавих хяналтыг сайжруулж, 2005 онд лимит хэтрүүлэн зарцуулсан албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэх

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2006 он 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 201/2332

Улаанбаатар-12
Утас: 262408
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал өгөх тухай

Үндэсний аудитын газраас яам, агентлагийн автомашин, үүрэн телефоны зардалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжүүдтэй санал нэг байна. Яам, агентлагуудын болон түүний харьяа байгууллагуудын албан тушаалтны автомашин, үүрэн телефон хэрэглэх зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн дээрх асуудалтай холбоотойгоор автомашин, үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Засгийн газрын одоогийн бүтэцтэй уялдуулах, зөвлөмжийн 1.8, 2.9-д тусгагдсан асуудлаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах ажлын хэсгийг Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулж, асуудлыг энэ онд багтаан шийдвэрлэх болно.



ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Ж.СҮХБААТАР